



## **АУДИТЫН КОД: САГ-2018/31/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор О.Баярмаа  
Утас: 260512 Цахим хаяг: [bayarmaao@audit.gov.mn](mailto:bayarmaao@audit.gov.mn)

“Баян ташаагийн эх Аудит” ХХК

Захирал: Т.Хоролсүрэн Утас:99116028,99062255

Цахим хаяг: [bte.audit@yahoo.com](mailto:bte.audit@yahoo.com)

Байршил: Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, П.Жамсрайн гудамж, 24/1 байр, 6,7 тоотууд

Улаанбаатар хот



**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**Агуулга**

|        |  |    |
|--------|--|----|
| 1      | Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2      | Аудитын тайлан .....   | 4  |
| 2.1    | Оршил .....  | 4  |
| 2.2    | Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл .....  | 4  |
| 2.3    | Байгууллагын хууль, эрх зүйн орчин .....   | 5  |
| 2.4    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа .....  | 5  |
| 2.5    | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....        | 5  |
| 2.6    | Дотоод хяналт .....  | 6  |
| 2.7    | Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....                     | 6  |
| 2.8    | Шилэн дансны мэдээлэл.....   | 6  |
| 2.9    | Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар .....  | 6  |
| 2.10   | Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....                     | 7  |
| 2.10.1 | Түрээсийн орлогоос зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлээгүй .....                  | 7  |
| 2.10.2 | Түрээсийн жишиг үнээс доогуур үнээр түрээсийн гэрээ байгуулсан.....                      | 7  |
| 2.10.3 | Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн .....                            | 8  |
| 2.10.4 | Бодлогын баримт бичиг нь санхүүгийн програмын дансны заавар, кодтой тохирохгүй байх..... | 8  |
| 2.11   | Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар .....  | 8  |
| 2.12   | Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....  | 8  |
| 2.13   | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....  | 8  |
| 2.14   | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....  | 8  |
| 2.15   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....  | 9  |
| 2.16   | Материаллаг байдал .....   | 9  |
| 2.17   | Санал дүгнэлтийн үндэслэл .....  | 9  |
| 3      | Менежментийн захидал .....   | 10 |
| 3.1    | Асуудал 1:Түрээсийн талаар .....   | 11 |
| 3.2    | Асуудал 2 :Анхан шатны баримтын талаар .....   | 12 |
| 3.3    | Асуудал 3: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар .....                 | 13 |
| 4      | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....                                 | 14 |
| 4.1    | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....   | 14 |
| 4.2    | Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....  | 15 |
| 4.3    | Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....  | 16 |
| 4.4    | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....   | 17 |



## 1 Аудитын гэрчилгээ

“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ц.СОДНОМДАМБА ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Аудитын гол асуудал

Тайлант онд “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь 3359.46 м2 талбайг 40 аж ахуй нэгж, байгууллага, хувь хүнд түрээсээр ашиглуулах гэрээ байгуулж түрээслэгчдээс 574,920.9 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн орлого оруулж санхүүжсэн боловч, уг түрээсийн орлогын 10 хувь буюу 57,492.9 мянган төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчил нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.



**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**Үүрэг, хариуцлага**

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын захирал Ц.Содномдамба танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тухайн Санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийхээр төлөвлөн “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ний аудитор Д.Түмэндэмбэрэл, аудитын менежер Ч.Чимгээ аудиторовн туслах Г.Хишигдулам, Д.Балжирдорж нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 13-нд 32 тоот албан ёсоор “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д ирүүлсэн байна.



### **2.3 Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

1972 онд анх шинжлэх ухаан, технологийн мэдээллээр иргэдэд үйлчлэх үүрэгтэй Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн төвийг байгуулж, 1974-1979 онд шинэ байр барьж ашиглалтанд оруулсан нь өнөөгийн Мэдээллийн технологийн үндэсний паркийн байр юм.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь эрхэм зорилгоо “Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ыг захирал нь удирдаж байна.

Тус байгууллагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох журам, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **2.5 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд Санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлсэн.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 29 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2010 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байгаа

## “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй, санхүүгийн программын дансны кодтой зөрүүтэй байна.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Новософт ХХК-ийн “Бааз” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

### 2.6 Дотоод хяналт

Бид Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

### 2.7 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 онд “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ нь өөрийн орлогоор санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн ба тайлант хугацаанд 1,469,466.5 мянган төгрөгийн орлоготой, 1,546,643.8 мянган төгрөгийн мөнгөн зарлагын гүйцэтгэлтэй ажилласан байна. Жилийн эцэст харилцах дансны үлдэгдэл 12,209.7 мянган төгрөг байна.

### 2.8 Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

Дараах мэдээллийг шилэн дансанд тогтмол байршуулсан байна. Үүнд

1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт,
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ,
4. Санхүүгийн тайлан,
5. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт,

### 2.9 Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 31 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

**Үр дагаврыг тодорхойлж чадвал:** Тайлант онд 3359.46 м<sup>2</sup> талбайг 40 аж ахуй нэгж, байгууллага, хувь хүнд түрээсээр ашиглуулах гэрээ байгуулж түрээслэгчдээс 574,920.9 мянган



## “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

төгрөгийн түрээсийн төлбөрийн орлого оруулж санхүүжсэн боловч, уг түрээсийн төлбөрөөс зохих журмын дагуу тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Шинжлэх ухаан технологийн сан, Оюуны өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газар, Нью Тур Сапарис ХХК нартай түрээсийн жишиг үнээс доогуур үнээр түрээсийн гэрээ хийсэн. Тус байгууллагын дарга, ерөнхий нягтлан бодогч нар нь бэлэн мөнгөний зарлагын баримтанд тодорхой цохолт хийхгүй зөвхөн гарын үсэг зурдаг, кассын нярав нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар бэлэн мөнгөний зарлагыг удаа дараа хийсэн. Нягтлан бодох бүртгэлийн дансны код санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй.

Өр төлбөрийн талаар

2016 онд 57.6 сая төгрөгийн өр төлбөр үүссэн бол 2017 онд 58 сая төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна. Гэхдээ 2016 оны 57.6 сая төгрөгийн өр төлбөрт өөрөөр хэлбэл жил бүрийн өсөж ирсэн өрийн төвшинг нэмэгдүүлэлгүй барьж харин бэлэн мөнгөний орлогын үлдэгдлийг 2 дахин нэмэгдүүлсэн юм. 58 сая төгрөгийн өр төлбөр богино хугацаат өрийн үлдэгдэл 19 сая төгрөг байсан \2016 онд 4.6 сая төгрөг\ бөгөөд зохицуулалтын шинжтэй зарим ажиллагаа он дамнан явагдсан тул төлж барагдуулаагүй тайланд тусгагдсан байдаг. Үүнийг шийдвэрлэсэн бөгөөд хасч тооцвол МТҮП сүүлийн гурван жилд хамгийн бага өр үүсгэж ажилласан буюу 2015 онд 84 сая, 2016 онд 57 сая, 2017 онд 39 сая төгрөгийн өр үүсгэж ажилласан байдаг.

### 2.10 Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

#### 2.10.1 Түрээсийн орлогоос зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлээгүй

- Тайлант онд "Мэдээллийн технологийн үндэсний парк" ТӨААТҮГ нь 3359.46 м2 талбайг 40 аж ахуй нэгж, байгууллага, хувь хүнд түрээсээр ашиглуулах гэрээ байгуулж түрээслэгчдээс 574,920.9 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн орлогын 10 хувь буюу 57,492.1 мянган төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн хорооны 2015 оны 363 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн В -д "Түрээсийн орлогын 20 хувийг Төрийн өмчийн хороонд төвлөрүүлнэ гэж заасны дагуу Төрийн өмчийн хорооны зөвшөөрлийг үндэслэн түрээсийн орлогыг 10 хувиар тооцон төвлөрүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн нийт орлогын 10 хувь буюу 57,492.9 мянган төгрөгийг улсын төсөвт нөхөн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

#### 2.10.2 Түрээсийн жишиг үнээс доогуур үнээр түрээсийн гэрээ байгуулсан

- "Мэдээллийн технологийн үндэсний парк" ТӨААТҮГ нь түрээслэгч Шинжлэх ухаан технологийн сантай 1м2-ыг 9585 төгрөгөөр, Оюуны өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газартай 1м2-ыг 4091 төгрөгөөр, Нью Тур Сафарис ХХКомпанитай 1м2-ыг 6000 төгрөгөөр тус тус түрээсийн гэрээ хийж түрээсийн төлбөр авч байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 119 дугаар тогтоолын Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай 1 дүгээр заалтаар "Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ", 2 дугаар заалтаар "Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний түрээсийн төлбөрийн хэмжээ нь батлагдсан жишиг үнээс багагүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, түрээсийн төлбөрийг жишиг үнээс багагүй байлгах зөвлөмж өгөх.





### 2.10.3 Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн

- Тус байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогч нар нь бэлэн мөнгөний зарлагын баримтанд тодорхой цохолт хийхгүй зөвхөн гарын үсэг зурдаг, кассын нярав нь 12 ширхэг 890,0 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуугаар бэлэн мөнгөний зарлага гаргасан байна. Энэ нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар батлагдсан Мөнгөн кассын ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.7-д "Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Захирал, ерөнхий нягтлан бодогч нар мөнгөн зарлагын баримтанд цохолт хийж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөх.

### 2.10.4 Бодлогын баримт бичиг нь санхүүгийн програмын дансны заавар, кодтой тохирохгүй байх

- Тус байгууллага нь 2010 оноос эхлэн уг нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горимыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2 "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулж байгууллагад ашиглагдах дансны кодыг санхүүгийн програмд нэвтрүүлэн дансны кодчилолтой ижил болгон мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

### 2.11 Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар

Аудитын явцад залруулах боломжгүй алдаа зөрчил гараагүй болно.

### 2.12 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

### 2.13 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын дараагийн аудитаар түрээсийн орлого, авлага, өр төлбөр барагдуулалтын талаар авч үзэх болно.

### 2.14 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 58,382.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 57,492.1 мянган төгрөгийн төлбөрийн 1 албан шаардлага хүргүүлж, 890.0 мянган төгрөгийн алдааг залруулах 3 зөвлөмж өглөө.



#### **2.15 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд Стандарт дүгнэлт Аудит ХХК аудит хийж нийт 4 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байна.

#### **2.16 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцов.

Тайлант оны санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр аудитын эрсдэлийн хэмжээ болон материаллаг байдлын түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, нийт зардлын 1,534,290.7 мянган төгрөгийг суурь болгон түүний 1 хувиар буюу 15,342.9 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж үзэхэд шинж чанар орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйл илрээгүй.

#### **2.17 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ**

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартд нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг үйлчлүүлэгч, түүний удирлдагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд санхүүгийн хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан байна.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын санхүүгийн албаны ажилтнуудад талархал илэрхийлье.

**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**3.1 Асуудал 1:Түрээсийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

"Мэдээллийн технологийн үндэсний парк" ТӨААТҮГ нь түрээслэгч Шинжлэх ухаан технологийн сантай 1м2-ыг 9585 төгрөгөөр, Оюуны өмчийн улсын бүртгэлийн ерөнхий газартай 1м2-ыг 4091 төгрөгөөр, Нью Тур Сафарис ХХКомпанитай 1м2-ыг 6000 төгрөгөөр тус тус түрээсийн гэрээ хийж түрээсийн төлбөр авч байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 119 дугаар тогтоолын Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай 1 дүгээр заалтаар "Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ", 2 дугаар заалтаар "Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний түрээсийн төлбөрийн хэмжээ нь батлагдсан жишиг үнээс багагүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, түрээсийн төлбөрийг жишиг үнийг мөрдөж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

**Төсвийн шууд захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг Төсвийн шууд захирагч асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



3.2 Асуудал 2 :Анхан шатны баримтын ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

**ҮАГ-ын ажиглалт**

Тус байгууллагын захирал ,ерөнхий нягтлан бодогч нар нь бэлэн мөнгөний зарлагын баримтанд тодорхой цохолт хийхгүй зөвхөн гарын үсэг зурдаг, кассын нярав нь 12 ширхэг 890,0 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуугаар бэлэн мөнгөний зарлага гаргасан байна. Энэ нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар батлагдсан Мөнгөн кассын ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.7-д "Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Захирал, ерөнхий нягтлан бодогч нар мөнгөн зарлагын баримтанд цохолт хийж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

**Төсвийн шууд захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг Төсвийн шууд захирагч асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Асуудал 3: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

**ҮАГ-ын ажиглалт**

Тус байгууллага нь 2010 оноос эхлэн уг нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горимыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-т "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулж байгууллагад ашиглагдах дансны кодыг санхүүгийн програмд нэвтрүүлэн дансны кодчилолтой ижил болгон мөрдөж ажиллах зөвлөмж өгөх,

**Эрсдэлүүд**

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 1нд Үндэсний аудитын газарт ирүүлэх


**Төсвийн шууд захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг Төсвийн шууд захирагч асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

## **4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

### **4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

| <b>Үзүүлэлт</b>                         | <b>Эхний үлдэгдэл<br/>2016.12.31.</b> | <b>Эцсийн үлдэгдэл<br/>2017.12.31.</b> |
|---|---------------------------------------|--|
| <b><u>ХӨРӨНГӨ</u></b>                   |                                       |  |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө       | 8,523,436.14                          | 16,354,097.93                          |
| Дансны авлага                           | 133,878,794.25                        | 101,984,141.64                         |
| Татвар, шимтгэлийн авлага               | -                                     | -                                      |
| Бусад авлага                            | 7,047,886.50                          | 8,062,193.39                           |
| Бараа материал                          | 33,624,147.95                         | 25,227,734.89                          |
| Урьдчилж төлсөн зардал                  | 7,573,498.67                          | 4,365,180.00                           |
| Эргэлтийн хөрөнгийн дүн                 | <b>190,647,763.51</b>                 | <b>155,993,347.85</b>                  |
| <b><u>Эргэлтийн бус хөрөнгө</u></b>     |                                       |  |
| Үндсэн хөрнгө                           | <b>2,365,814,284.18</b>               | <b>1,600,187,029.28</b>                |
| Биет бус хөрөнгө                        |                                       |  |
| Биологийн хөрөнгө                       | -                                     | -                                      |
| Бусад эргэлтийн хөрөнгө                 |                                       |  |
| <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>                     | <b>2,556,462,047.69</b>               | <b>1,756,180,377.13</b>                |
| <b><u>ӨР ТӨЛБӨР</u></b>                 |                                       |  |
| <b><u>Богино хугацаат өр төлбөр</u></b> |                                       |  |
| Дансны өглөг                            | 38,200,500.00                         | 29,481,300.00                          |
| Цалингийн өглөг                         | -                                     | 267,099.86                             |
| Бусад өглөг                             | 4,654,258.31                          | 89,916,883.06                          |
| НДШ-ийн өглөг                           | 6,923,691.95                          |  |
| Хүүгийн өглөг                           | 70,283,626.58                         | -                                      |
| Татварын өглөг                          | 164,129,623.32                        | 213,849,267.11                         |
| Урьдчилж орсон орлого                   | 791,822,893.84                        | 19,690,376.50                          |
| Банкны богино хугацаат зээл             |                                       |  |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b> | <b>1,076,014,594.00</b>               | <b>353,204,926.53</b>                  |
| <b><u>Урт хугацаат өр төлбөр</u></b>    |                                       |  |
| Урт хугацаат зээл                       | 5,986,296.39                          | 5,986,296.39                           |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>    | <b>5,986,296.39</b>                   | <b>5,986,296.39</b>                    |
| <b>Нийт өр төлбөр</b>                   | <b>1,082,000,890.39</b>               | <b>359,191,222.92</b>                  |
| <b><u>Эздийн өмч</u></b>                |                                       |  |
| Төрийн                                  | 1,021,630,200.00                      | 1,021,630,200.00                       |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл     | 1,583,463,801.58                      | 1,583,463,801.58                       |
| Эздийн өмчийн бусад хэсэг               | 116,214,381.42                        | 116,214,381.42                         |
| Хуримтлагдсан ашиг                      | - 1,246,847,225.70                    | - 1,324,319,228.79                     |
| <b>Нийт эздийн өмч</b>                  | <b>1,474,461,157.30</b>               | <b>1,396,989,154.21</b>                |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b> | <b>2,556,462,047.69</b>               | <b>1,756,180,377.13</b>                |





**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

|   | <b>2016.12.31.</b>      | <b>2017.12.31.</b>     |
|---|-------------------------|------------------------|
| Борлуулалтын орлого                                 | 604,335,716.70          | 625,199,769.06         |
| Борлуулалтын өртөг                                  | -                       | -                      |
| Нийт ашиг /алдагдал/                                | 604,335,716.70          | 625,199,769.06         |
| Хүүний орлого                                       | 661,087.30              | 118,288.13             |
| Түрээсийн орлого                                    |                         |                        |
| Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого              |                         |                        |
| Бусад орлого  | 776,168,749.18          | 844,148,418.61         |
| Ерөнхий удирдлагын зардал                           | 56,686,921.05           | 53,658,693.28          |
| Борлуулалт маркетингийн зардал                      | 1,447,460,931.44        | 1,480,632,047.67       |
| Санхүүгийн зардал                                   |                         |                        |
| Бусад зардал  | 32,592,407.33           | 12,353,026.05          |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, /гарз/         |                         | - 129,243.57           |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, /гарз/       |                         |                        |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/          | 1,806,663.46            | - 18,031.38            |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/</b>         | <b>- 153,768,043.18</b> | <b>- 77,324,566.15</b> |
| Орлогын татварын зардал                             | 66,109.73               | 11,828.80              |
| <b>Татварын дараах ашиг/алдагдал/</b>               | <b>- 153,834,152.91</b> | <b>- 77,336,394.95</b> |
| <b>3. Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал</b> |                         |                        |
| Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)              |                         |                        |
| Валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэн ашиг (алдагдал)   |                         |                        |
| Орлогын татварын зардал                             |                         |                        |
|   |                         |                        |
| <b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ</b>            | <b>- 153,768,043.18</b> | <b>- 77,324,566.15</b> |



**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**


| Үзүүлэлт                                    | Өмч                     | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт                    |
|---|-------------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------------|-------------------------|
| 2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл        | 1,021,630,200.00        | 1,583,463,801.58                    | 116,214,381.42            | -<br>1,246,847,225.70         | 1,474,461,157.30        |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа         |                         |                                     |                           |                               |                         |
| Залруулагдсан үлдэгдэл                      |                         |                                     | 116,214,381.42            | -<br>1,246,847,225.70         | 1,474,461,157.30        |
| Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)     |                         |                                     |                           | -<br>77,336,394.96            | -<br>77,336,394.96      |
| Хуваарилсан ногдол ашиг                     |                         |                                     |                           |                               |                         |
| Хувьцаат капиталын өсөрт, бууралт           |                         |                                     |                           |                               | -                       |
| 2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл        | 1,021,630,200.00        | 1,583,463,801.58                    | 116,214,381.42            | -<br>1,324,183,620.66         | 1,397,124,762.34        |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа         |                         |                                     |                           | -<br>135,608.13               | -<br>135,608.13         |
| Өмнөх үеийн үр дүн                          |                         |                                     |                           |                               | -                       |
| Тайлант үеийн үр дүн                        |                         |                                     |                           | -                             | -                       |
| Хуваарилсан ногдол ашиг                     |                         |                                     |                           |                               | -                       |
| Хувьцаат капиталын өсөрт, бууралт           |                         |                                     |                           | -                             |                         |
| <b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b> | <b>1,021,630,200.00</b> | <b>1,583,463,801.58</b>             | <b>116,214,381.42</b>     | <b>-<br/>1,324,319,228.79</b> | <b>1,396,989,154.21</b> |



**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

**4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Үзүүлэлт   | 2016.12.31.           | 2017.12.31.           |
|--|-----------------------|-----------------------|
| <b>1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                        |                       |                       |
| <b>1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>                | <b>701,353,499.16</b> | <b>761,408,078.12</b> |
| Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого                    | 659,772,365.31        | 743,938,503.87        |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                         | 2,538,260.00          | 4,990,745.00          |
| Бусад мөнгөн орлого  | 39,042,873.85         | 12,478,829.25         |
| <b>1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>               | <b>771,751,959.71</b> | <b>769,879,592.62</b> |
| Ажиллагчдад төлсөн   | 306,100,762.19        | 301,373,681.31        |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө                   | 76,470,835.90         | 90,315,867.45         |
| Бараа материал худалдан авахад төлсөн                          | 11,554,310.00         | 14,165,197.75         |
| Ашиглалтын зардал  | 211,280,496.52        | 155,535,314.45        |
| Түлш шатахуун тээврийн хөлс сэлбэг хэрэгслэлд төлсөн           | 3,214,772.73          | 6,346,499.93          |
| Хүний зардалд төлсөн   | -                     | -                     |
| Татварын байгууллагад төлсөн                                   | 28,890,570.26         | 66,239,350.00         |
| Даатгалын төлбөрт төлсөн                                       | -                     | 329,100.00            |
| Бусад зардал   | 134,240,212.11        | 135,574,581.73        |
| <b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>                    | <b>70,398,460.55</b>  | <b>8,471,514.50</b>   |
| <b>2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>     |                       |                       |
| <b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>                   | 661,097.30            | 66,575,176.29         |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                               |                       |                       |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого                             |                       |                       |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого                             |                       |                       |
| Хүүний орлого  | 661,097.30            | 118,288.13            |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт         | -                     | 66,456,888.16         |
| <b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>                  | -                     | 66,778,000.00         |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө                      | -                     | -                     |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө                    |                       |                       |
| Хөрөнгө оруулалтолж эзэмшихэд төлсөн мөнгө                     |                       |                       |
| Бусдад олгосон зээл, болон урьдчилгаа                          |                       | 66,778,000.00         |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b> | <b>661,097.30</b>     | <b>202,823.71</b>     |
| <b>3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>             |                       |                       |
| <b>Мөнгөн орлогын дүн</b>                                      |                       | <b>46,605,000.00</b>  |



**“Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит**

|  |                      |                      |
|--|----------------------|----------------------|
| Зээл авсан,өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан           | -                    | 16,505,000.00        |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан |                      |                      |
| Төрөл бүрийн хандив  |                      |                      |
| <b>Мөнгөн зарлагын дүн</b>                                   | -                    | -                    |
| Зээл авсан,өрийн үнэт цаас гаргасны төлбөрт төлсөн           | -                    | -                    |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн                           |                      |                      |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан |                      |                      |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>       | -                    | <b>16,505,000.00</b> |
|  |                      |                      |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                              | <b>69,737,363.25</b> | <b>7,830,661.79</b>  |
| <i>Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>      | <i>78,260,799.38</i> | <i>8,523,436.14</i>  |
| <i>Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>     | <i>85,234,636.14</i> | <i>16,354,097.93</i> |

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

